



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/566

Булган сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн Х/74 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Аймгийн тэжээлийн нөөц бүрдүүлэх” төсөл арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны
дарга:

Г.Гантулга (Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт,
бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Гишүүд:

Э.Уянга (Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт,
бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Н.Пүрэвсайхан (Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга)

Иргэний төлөөлөл:

Б.Туяа (Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга:

Г.Дэлгэр (Худалдан авах ажиллагааны газрын
мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Г.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6325010775